

**"МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" -ИЙН
2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ [1]	Төсөв /сая төг/[2]		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт [3]	Суурь түвшин [4]		Зорилтот түвшин [5]		Хэрэгжилт [6]	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь [7]	Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлба) [8]
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<p>Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт 2.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ:</p>											
1	2.3.1. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.	-	-	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулах	2020	Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан.	2023	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2023.11.01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн олонх буюу 85.7 хувь нь дэмжиж, нэгдсэн хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэсэн. УИХ-ын чуулганы 11 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн 58 хувь нь дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж, ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	100	
2	2.3.2. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник	22.50 0.000	22.500.00 0	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадварыг дэмжих, урамшуула	2020	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд	2023	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 212.4.-т Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу Хүүхдийн төлөө	100	

<p>сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.</p>				<p>х эрх зүйн орчин бүрдсэн байна.</p>	<p>нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан</p>		<p>болон дагалдан Хүүхдийн эрхийн тухай, Автотээврийн тухай хуулиудын нэмэлт өөрчлөлтийг батлуулсан байна.</p>	<p>сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор батлуулсан. Хүүхдийн төлөө сангаас хүүхдийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалт, олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж, урамшуулах, мөн олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлнэ. Журамд заасан болзол шалгуур хангасан хүүхдүүдийн шагнал урамшуулал, дэмжлэг үзүүлэхэд 2021 онд 15 хүүхдэд 25,0 сая төгрөг, 2022 онд 121 хүүхдэд 272,7 сая төгрөг, 2023 онд 64 хүүхдэд 149,7 сая нийт 200 хүүхдэд 447,7 сая төгрөг зарцуулжээ. Журам хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд санд автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос 11,0 тэрбум төгрөг, "Хүүхдийн фонд" ТББ-аас 2,1 тэрбум төгрөг, байгууллага, иргэдээс өгсөн хандив 17,2 сая төгрөг, нийт 13,1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс 2023 оны жилийн эцсийн байдлаар 12,8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2023 оны 04 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагч, иргэд, байгууллагад мэдлэг олгох сургалтыг тухайн орон нутагтаа зохион байгуулах үндэсний сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтад</p>	
---	--	--	--	--	--	--	--	--	--

								<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, нийслэл, аймаг дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтсийн хүүхдийн хөгжил, оролцооны асуудал хариуцсан 38 мэргэжилтнүүд хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн. Эдгээр сургагч багш нарыг тухай орон нутагтаа сургалт зохион байгуулах чиглэлийг 2023 оны 11/2831 тоот албан бичгээр хүрүүлж, сургалтыг зохион байгуулсан. Сургалтын тайлан нэгтгэгдэж байгаа болно.</p> <p>Хүчирхийлэл, мөлжлөгийн хэлбэрүүдийг таньж мэдэх, өөрийгөө болон найз нөхдөө, хүүхдүүдээ хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдээллийг түгээх “Чи ганцаараа биш” нөлөөллийн аяныг 2023 оны 10-11 сард үндэсний хэмжээнд зохион байгуулж, нийт 375 гаруй байгууллагын 26,148 гаруй ажилтан, 22305 эцэг эх, 64,300 гаруй сурагч хамруулсан. Мөн цахим сүлжээгээр 323,919 хүн мэдээлэл хүргээд байна.</p> <p>Ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчид, багш, ажилтнууд, олон нийтийн дунд үе тэнгийн дарамт дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, энэ төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилготой “Найз байя” үндэсний аяныг 21 аймаг 9 дүүрэгт зохион байгуулж, 86129 хүүхэд, 8080 эцэг эх, 8572 багш 9680 албан хаагчдад мэдээлэл өгч, 11 төрлийн контент бэлтгэн түгээлээ.</p>	
--	--	--	--	--	--	--	--	---	--

3	2.3.3. залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирна.	-	-	Нийт залуучуудын 40 хувьд гэр бүлийн зөвлөгөөг хүргэх	2020 ЗХТ-өөр үйлчлүүлсэн залуучуудын тоо 2020 онд 23 хувь	2023	ЗХТ-өөр үйлчлүүлсэн залуучуудын тоо 45 хувьд хүрсэн байна.	<p>Аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн 43 төвөөр 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 414007 залуучууд буюу 15-34 насны нийт залуучуудын 41 хувь нь үйлчлүүлж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих 7 төрлийн арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан. Залуу гэр бүлийг дэмжих хүрээнд Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дорнод, Дорноговь, Увс, Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан аймаг болон нийслэлийн Налайх дүүргийн Залуучуудын хөгжлийн төвүүд гэр бүл болж буй залуучуудыг гэр бүлийн боловсрол олгох, жендэрийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад хамруулснаар гэр бүлийг батлах ёслолыг зохион байгуулдаг бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар тус арга хэмжээнд нийт 150 гаруй залуучуудыг хамруулсан. Залуу гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, харилцаан дахь зөрчилтэй, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд нь туслах, мэргэжлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Залуучуудын хөгжлийн төвийн сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн бөгөөд сэтгэл зүйн зөвлөгөөг 500, хууль зүйн зөвлөгөөг 254 залуучууд авсан байна. Мөн залуу гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх, залуучуудын цахим боловсролыг дэмжих, цахим орчинд хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжих үүднээс төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд “Unitel” групптэй хамтран “Unitel hub” цахим сургалт, мэдээллийн цэгийг</p>	90	
---	--	---	---	---	--	------	--	--	----	--

								орон нутаг дахь Залуучуудын хөгжлийн төвүүдийн дэргэд байгуулаад байна. Тус төвийг 2022 онд Дархан-Уул аймагт туршилтаар байгуулсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар Архангай, Баян-Өлгий, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, Увс, Ховд, Хөвсгөл зэрэг 11 аймагт байгуулсан. "Unitel hub" танхимаар дамжуулан өсвөр үеийнхэн, залуучуудад электроникийн суурь ойлголт, мэдлэг олгох Робокид, Электрокид сургалтуудыг зохион байгуулж, суурин компьютер, ухаалаг таблет, өндөр хурдны интернет ашиглан кино үзэх /IPTV/, ном унших, сонсох зэрэг хөгжлийн үйлчилгээнүүдийг үзүүлж, 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 500 гаруй өсвөр үе, залуучуудыг хамруулсан.			
4	Арга хэмжээ 2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.	-	-	1.Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай	1.Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтийн дундаж 90.2 хувьтай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн гэж" үнэлэгдсэн. 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний	1.Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтийн дундаж 90.2 хувьтай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн гэж" үнэлэгдсэн. 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний	2021-2025	Хөтөлбөрд дийн хэрэгжилтийг хангасан байна. -Хуулийн төслийг эцэслэн боловсруулсан байна. -Зардлын тооцоог боловсруулсан байна. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон 20-аас доошгүй хуульд нэмэлт	1. "Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр" нь Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд 2020-2023 онд хэрэгжинэ. Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах, тэднийг эрүүл урт наслуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, амьдрах орчин нөхцлийг сайжруулахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршиж байгаа бөгөөд 4 үндсэн зорилтоос бүрдэж байна. Тэдгээр 4 зорилтын хүрээнд нийт 58 арга хэмжээг 75 шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтийн дундаж 90.2 хувьтай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. Уг үндэсний	100	

			<p>анхдагч хуулийн төслийг боловсруул ах: Үүнд: -Үзэл баримтлал 1 -Хуулийн төсөл 1 -Тандан судалгаа -Зардлын тооцоо 1 -Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 1. 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах 4. Саадгүй байдал, хүртээмжин тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан батлуулах 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулах</p>	<p>йг дэмжих үндэсний хөтөлбөр 2018-2022 онд хэрэгжинэ. 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 онд батлагдан хэрэгжиж байна.</p>	<p>эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтийн дундаж 81.0 хувьтай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. 3. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь 12 бүлэг, 45 зүйлтэй. 4. Саадгүй байдал, хүртээмжин тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж байна. 5. Орон нутаг одоогоор хөгжлийн бэрхшээлт</p>	<p>өөрчлөлт оруулах санал боловсруулсан байна. -ХБИ болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна.</p>	<p>хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг 2022 оны 03 дугаар сард дүгнэсэн. Үндэсний хөтөлбөрийн биелэлт 90.0 хувьтай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдлээ. ХНХ-ын сайдын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/47 тоот тушаалаар "Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсан бөгөөд он тус бүрээр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлсон. Хамтран ажиллах байгууллагууд 2022 оны төлөвлөгөөний дагуу арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монголын Ахмадын Холбоотой 2022 онд хамтран ажиллах гэрээнд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн улсын төсвөөс 124,9 сая төгрөгийг төсөвлөн хэрэгжүүлж байна. 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэх зорилготой. Уг хөтөлбөр нь Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд 2018-2022 онд хэрэгжсэн. Үндсэн 8 зорилтын хүрээнд нийт</p>	
--	--	--	---	---	---	---	--	--

			<p>6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийг байгуулах</p> <p>7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлэх</p> <p>8. Ахмад настныг /ажилтныг/ тэтгэвэрт бэлтгэх жишиг загварыг хэрэгжүүлэх.</p>	<p>эй хүний хөгжлийн төв байхгүй.</p> <p>6. Одоогоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төв байхгүй.</p> <p>8. 2020 онд 4000 гаруй байгууллага хэрэгжүүлсэн.</p>	<p>114 үйл ажиллагааг төлөвлөсөн бөгөөд 2020 оны биелэлтийн дундаж 81.0 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн.</p> <p>3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ХЗДХ-ийн сайдтай хамтран үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төслийг яамд болон холбогдох төрийн болон ТББ-дад танилцуулан саналыг тусгасан бөгөөд ойрын хугацаанд ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь 12 бүлэг, 45 зүйлтэй бөгөөд шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 12 бүлэг, 43 зүйлтэй болж, үндсэн асуудлаар 1 бүлэг, шинээр 6 зүйл нэмэгдэж, хуулийн 70 гаруй хувьд нь нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга орсон байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг хамтад нь батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл, хуулийн тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоог боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг дагалдан 20 гаруй хуульд</p>	
--	--	--	---	--	---	--

нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.

Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлсэн бөгөөд ирсэн саналыг тусган ажилласан.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар үзэл баримтлалын төсөл, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн тайлан, үзэл баримтлалын төслийн танилцуулгын хамт 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/3015 тоот бичгээр хүргүүлсэн.

Мөн хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрөл авах албан тоот хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Хуулийн III бүлэг буюу хүртээмжтэй орчин нөхцөлийн 8-12 дугаар зүйл нь Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд орж байгаа бөгөөд үндсэн асуудлаар шинээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сантай холбоотой 1 бүлэг, хүний нөөц бэлтгэх, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, салбарын нийгмийн хамгааллын асуудлаар 3 зүйл нэмэгдэж, хуулийн 70-с дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байна

4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн

бие даан оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах мөн тэдэнд барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо зэрэг үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан. Энэ оны 12 дугаар сард хуулийн төслийг холбогдох төрийн болон ТББ-дын төлөөлөлд танилцуулж, саналыг тус Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулсан бөгөөд 6 бүлэг, 23 зүйлээс бүрдэх юм. Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлсэн бөгөөд ирсэн саналыг тусган ажилласан.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар үзэл баримтлалын төсөл, хуулийг хэрэгжүүлэх урьдчилсан тандан судалгаа, үзэл баримтлалын төслийн танилцуулгын хамт 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/3060 тоот бичгээр хүргүүлсэн. Мөн хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрөл авах албан тоот хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг

эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг даган гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

5. Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Архангай, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Ховд аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулахаар төлөвлөсөн.

Үүний дагуу төвийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/159 дүгээр тушаалаар баталж, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Ховд аймгийн ХБХТ-ийн барилгыг 2022 онд хүлээн авсан.

Төвийн үйл ажиллагааг 2023 оны 9 дүгээр сараас эхлэн үзүүлж, 11 дүгээр сарын байдлаар 2053 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд үзлэг, сургалт мэдээлэл, эмчилгээ, зөвлөгөөний үйлчилгээ үзүүлсэн байна.

Архангай аймагт баригдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга 50%-ийн гүйцэтгэлтэй байна.

6. Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Улаанбаатар хотод байгуулагдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын

угсралтын ажлыг 2022 онд “Би энд Би” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, барилга угсралтын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй байна

7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт **4725** иргэн хамрагдаж, **9,075,515,641** төгрөгийг зарцуулсан, хэрэгжилт **79.6** хувьтай байна. Үүнээс:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд 51 иргэн хамрагдаж **279,489,000** төгрөгийг;
- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд **3527** иргэн хамрагдаж, **6,964,223,500** төгрөгийг;
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад **589** иргэн хамрагдаж, **107,482,400** төгрөгийг;
- Борлуулалтын болон түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд **537** иргэн хамрагдаж, **190,204,650** төгрөгийг;
- Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд **21** иргэн хамрагдаж **114,260,000** төгрөгийг;

									<p>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 1,419,856,091 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p> <p>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн талаар:</p> <p>-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 561 иргэн хамрагдаж, 476,810,000 төгрөгийг;</p> <p>-Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1057 иргэн хамрагдаж, 4,604,100,000 төгрөгийг тус тус зарцуулаад байна.</p> <p>8. ХНХЯ-ны аймаг, нийслэлийн ахмадын хорооны дарга нартай байгуулсан Хамтран ажиллах гэрээнд Ахмад настныг тэтгэвэрт гарахад бэлтгэх чиглэлээр ажил олгогчийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настан /ажилтан/-ыг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх жишиг загварыг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2022 онд 7228, 2023 онд 7938 аж ахуйн нэгж байгууллага хэрэгжүүлж байна.</p> <p>Энэхүү хөтөлбөр нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн ахмад ажилтны нийгмийн оролцоог дэмжих, эдийн засгийн баталгааг хангах, орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хадгалж, тэднийг байгууллага, хамт олныхоо дэмжлэгээр ажил хөдөлмөрийн идэвхтэй үеэс амьдралын дараагийн үедээ сэтгэл хангалуун шилжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.</p>	
5	2.3.5. хүүхдийн эрхийг дээдлэн,	36.36 0.000	26.360.00 0	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд	2020	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд	2023	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд	- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороод аймаг, дүүрэг, сум дундын шүүхтэй сумдад байгуулагдаж, 38 хороонд 522 гишүүн хуулиар	100

	аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно.			хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулж ах		хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдсэн.		хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	хүлээсэн чиг үүргийн дагуу ажиллаж, 1840 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна. - Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан үзэл баримтлалын дагуу боловсруулж, дагалдах Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн хамт 20 гаруй удаагийн хэлэлцүүлээ. Хэлэлцүүлгийн хүрээнд Засгийн газрын гишүүд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, анхан, дунд шатны салбар бүрийн нийгмийн ажилтан 800 гаруй хүүхэд болон иргэдийг саналыг тусган боловсруулсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцэхийг Улсын Их Хурлаас дэмжсэн болно. Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг хийж байна.	
Зорилт 2.6. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ:										
6	2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг	-	-	1.хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг шинэчлэх 2.хөдөлмөрийн аюулгүй байдал,	2020	1.ХТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн	2023	1.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг шинэчлэгдсэн байна. 2. ХАБЭАТХ-д нэмэлт	1. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа баталсан. Хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна. 2. Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдэж байгаатай	70

	шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгоно.			эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчлэх			өөрчлөлт оруулсан байна.	холбогдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/214 дугаар тушаалаар байгуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих” төслийн дэмжлэгтэйгээр хууль эрх зүйн актын зохицуулалт, уялдаа холбоог судлах дүн шинжилгээ хийж, дотоодын зөвлөхтэй хамтран ХАБЭА-н тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.		
7	2.6.2. ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	59.7 тэрбум төгрөг ХЭДС	Жилийн эцсийн байдлаар 49.2 тэрбум төгрөг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр–5; Тушаал; удирдамж.	2021	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор үндсэн 5 хөтөлбөрийг баталсан. ХЭҮЗ-ийн 2022 оны 01 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан үндсэн 7 хөтөлбөр болгон баталсан.	2023	Хөтөлбөрүүдийн төслийг хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр оруулан батлуулсан байна. Холбогдоох удирдамж, бичиг баримтыг сайдын тушаалаар батлуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нийт 126845 иргэн хамрагдаж, 49.2 тэрбум төгрөгийг зарцуулсан. Үүнээс: -Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 78734 иргэн хамрагдаж, 1,2 тэрбум төгрөгийг; -Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 16017 иргэн хамрагдаж, 1,3 тэрбум төгрөгийг;	100	

									Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар авч үзвэл: Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад 594 иргэн хамрагдаж, 99,504,200 төгрөгийг зарцуулсан байна.		
9	2.6.4. албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.	-	-	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийн сан-1	-	-	2023	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх сүүлийн 10 жилийн тоо, мэдээллийг үүсгэсэн байна.	<p>Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тодорхой хүрээг хамарч буй одоо ашиглагдаж буй системүүд болон тэдгээрийн зарим модулиудыг албан бус хөдөлмөрийг албажуулахад ашиглах боломжтой байна. Одоогийн байдлаар албан бус хөдөлмөрийг албажуулах асуудал нь аль ч системийн хувьд үндсэн зорилтод хамаарахгүй байгаа бөгөөд тухайн системүүдээс албан бус хөдөлмөр эрхлэлтийн зохистой мэдээллийн сан үүсгэхэд хүндрэлтэй байна. Иймд албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлийг нэг дор цуглуулах, боловсруулах боломжийг бий болгосон шийдэл боловсруулах, оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, манлайллыг бий болгох чиглэлээр ОУХБ-тай хамтран 300 мянган долларын төсөл хэрэгжүүлэхээр төслийн нэгжийг 2023 оны 8 дугаар сард байгуулсан. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албажуулах талаар төрийн бодлого нь Алсын хараа-2050, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон бусад баримт бичгүүдэд дараах байдлаар тусгагдсан. Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын 8.3, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1, 3.3 дахь зорилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг</p>	30	

--	--	--	--

--	--

15 хувь нэмэгдэх бөгөөд нийт 141.3 тэрбум төгрөг зарцуулсан;
-Төрийн нийтлэг үйлчилгээний 22.0 мянган албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 8 хувиар нэмэгдүүлсэн ба нийт 54.5 тэрбум төгрөг зарцуулсан.
- Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 20 хувийн орон нутгийн нэмэгдлийг улсын төсвөөс олгодог болсон. Орон нутагт ажиллаж байгаа 12.0 мянган албан хаагчид 33.9 тэрбум төгрөг зарцуулсан;
- Төрийн албан хаагчийн ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгодог болсон. Энэ арга хэмжээний хүрээнд 160.0 мянган албан хаагчдын цалин 2-5 хувиар нэмэгдэх ба нийт 50.1 тэрбум төгрөг зарцуулах юм.

2.Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дунджаар 26-60 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.
Энэ хүрээнд төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 590 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн нийтлэг үйлчилгээний /ТНУ/ албан хаагчдын цалингийн доод хэмжээ 565 мян.төгрөг байгааг 750.0 мянган төгрөгт, төрийн захиргааны албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн тусгай албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт хүргэсэн.

--	--

Дээрх арга хэмжээний хүрээнд 2023 онд нийт 991.5 тэрбум төгрөг зарцуулахаар байна.

3.Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцийн түвшинтэй (Инфляцийн түвшин 2023 оны 8 дугаар сарын байдлаар 10 хувьтай байна) уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхээр тооцон Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгалаа. Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэх бөгөөд уг арга хэмжээнд 532.4 тэрбум төгрөг шаардагдана.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго 3.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилт 3.1.Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ:

11	3.1.1. нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.	238.5 мян.\$	130 мян.\$	Хуулийн төсөл	2020	Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна.	2023	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	<p>Монгол Улсын Засгийн газар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шатлгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг тус тус 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжснээр олон давхаргат тэтгэврийн тогтолцог нэвтрүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, хуримтлал үүсгэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх зэрэг томоохон өөрчлөлтийг хийх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Харин Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-ын 2023 оны намрын чуулганаар батлахаар ажлын хэсэг ажиллаж байна.</p> <p>Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих эрх зүйн орчин бүрдээд байна. Тухайлбал, 2024 оноос эхлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.1-д “энэ хуулийн 18.1-</p>	100	
----	---	--------------	------------	---------------	------	---	------	--	---	-----	--

									д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого;" гэж заасны дагуу шимтгэлийн орлогыг хуримтлал болгох арга хэмжээ үе шаттай хэрэгжиж эхлэх юм.		
			Хуримтлалын нэгдсэн сан байгуулагд аагүй байна.	2020	Шинээр боловсруулах	2023	Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/64 дүгээр тушаалаар Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж хуулийн төслийг боловсруулах чиглэлээр ажлын хэсгийн хурал 3 удаа, хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан.</p> <p>Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах, хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2023 оны 06 сарын 07-ны өдөр байгуулсан. Тус гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан.</p> <p>Монгол Улсын онцлогт нийцсэн Хуримтлалын тогтолцоог бий болгох Хуримтлалын нэгдсэн сангийн хууль, эрх зүйн орчныг</p>			

									бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэрийн хамт боловсруулсан. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Хуримтлалын нэгдсэн сангийн орлого, зарлагын хэтийн төлөвийг тооцох актуар тооцооллыг хийж байна.		
12	3.1.2. Иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийгдэнэ	-	-	Хуулийн төсөл	2020	Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.	2023	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байна.	Монгол Улсын Засгийн газар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Шинэчлэн батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх” харилцааг зохицуулахаар тусгасан.	100	
13	3.1.3. нийгмийн халамж зорилгод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.	33.6 тэрбум төгрөг	30.7 тэрбум	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний хэрэгжилтийн байдалд судалгаа хийж, Хүнсний эрхийн бичиг олгох журамд өөрчлөлт оруулах шийдвэрийн төслийг боловсруулах	2020	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаал 2020 онд 242988 иргэнд нийт 52.2	2023	Нийгмийн халамжийн зарим үйлчилгээнд цахимаар хүсэлт гаргах, хэрхэн хамрагдах талаар иргэд олон нийтэд мэдээлэл түгээх, сурталчлан таниулах ажлыг хийсэн байна.	Монгол Улсын Их Хурлаас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн үйлчилгээ болгон зорилгод бүлэгт чиглүүлэх зорилгоор “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 236 дугаар тогтоолоор хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам батлагдаж хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгохоор болсон. Үүнтэй холбоотойгоор иргэдэд үйлчилгээг ойртуулах, хүндрэл чирэгдлийг багасгах, ил тод нээлттэй байлгах ажлын хүрээнд e-mongolia цахим системээр дамжуулан хүүхдийн	90	

					тэрбум төгрөг зарцуулсан.			мөнгөнд хамрагдах хүсэлт гаргах боломжийг бүрдүүлж хөгжүүлэлтийг хийсэн бөгөөд e-mongolia, ehalamj.mn системд хүсэлт гаргах, хүүхдийн төлөө санд шилжүүлэх, шилжүүлэг цуцлах, дансны мэдээлэл бүртгэх зэрэг шинэчлэлийн текст, нөхөн олгох, хүсэлт гаргасан хүүхэд бүрт олгохтой холбоотой зурагт хуудас, шторк, боршур хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон ХНХЯ, ХХҮЕГ, аймаг дүүргийн ХХҮГ, ХХҮХ-үүд өөрийн цахим хуудсаараа дамжуулан иргэдэд мэдээллийг түгээн ажиллалаа.		
				Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх	2020	Нийгмийн халамжийн Үйлчилгээн ний 30 хувийг цахимжуулсан байна.	2023	Нийгмийн халамжийн цахимжуулсан үйлчилгээний тоо 64 болж нэмэгдэн, иргэд үйлчилгээг чирэгдэлгүй, хялбар авах боломжтой болсон байна. Нийгмийн халамжийн нэгдсэн систем"-ийг 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс улсын хэмжээнд нэвтрүүлж эхэлсэн. Нийгмийн халамжийн цахимжуулсан үйлчилгээний тоо 14 байсан бол 2021 онд 12 үйлчилгээг, 2022 онд 48 үйлчилгээг нэмж цахимжуулснаар 2023 оны байдлаар нийт 64 үйлчилгээ буюу нийгмийн халамжийн бүх үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлээ. Түүнчлэн цаг үеийн өөрчлөлт болон салбар хоорондын цахимжилттай холбоотойгоор хавсралтаар оруулж байгаа цаасан материалыг бусад салбараас цахим хэлбэрээр авах зэрэг хөгжүүлэлт хийх, сайжруулах, ажлыг төлөвлөн ажиллаж байна.		
14	3.1.4. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ,	4500 \$	4500\$	Аргачлал батлуулах	2020	Аргачлал шинэчлэгд ээгүй.	2023	Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлсэн аргачлал батлагдсан байна. Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хамтарсан А/84, А/89 тоот тушаалаар Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэн баталсан. Засгийн	100	

<p>шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.</p>						<p>газраас төрийн байгууллагуудын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрд цугларсан их өгөгдлийг төрийн бодлого шийдвэрт ашиглах, төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчин бүрдэж эхэлсэнтэй холбоотойгоор өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Ингэхдээ төрд байгаа мэдээлэлд суурилан өрхийн орлогыг орлуулан тооцох боломжтой, өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлэхээр зорьсон.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан нийт хүүхдийн 91 хувьд олгохтой холбоотой "Орлогыг орлуулан тооцох аргаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал", "Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал"-ыг тус тус боловсруулж Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/14, А/04 дүгээр хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан. Энэхүү аргачлалыг шинэчлэн батлахдаа 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг үндсэн мэдээлэл болгож ашигласан бөгөөд үүн дээр нэмж төрийн мэдээллийн санд бэлэн байгаа, хууль, эрх зүйн орчны хүрээнд ашиглах боломжтой өрх, иргэний мэдээллийг регистрийн дугаараар</p>	
---	--	--	--	--	--	---	--

					<p>холбон холимог мэдээллийн сан үүсгэсэн.</p> <p>-Уг аргачлалын дагуу хүүхдийн мөнгийг 91 хувьд олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>-Мөн түүнчлэн уг аргачлалын дагуу хүнсний эрхийн бичигт хамрагддаг 26.9 мянган өрхөөс судалгаа авах ажлыг 2023 оны 5 дугаар сард зохион байгуулж ажилласан.</p> <p>Энэ хүрээнд:</p> <p>Орлогыг орлуулан тооцох аргачлал /ООТА/-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/36 дугаар тушаалыг батлуулсан.</p> <p>Уг тушаалын дагуу судалгааг АХБ-ны "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2"-ийн батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахаар ажлын удирдамж, төсвийн тооцооллыг бэлтгэж, АХБ болон Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p>ООТА-аар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 26,900 өрхийг хамруулан улсын хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр эхлүүлсэн.</p> <p>Зөөврийн төхөөрөмжид зориулсан судалгааны программыг үндсэн системийн хамт ашиглалтад оруулж, 21 аймаг, 9 дүүргийн ХХҮГ/ХХҮХ-ийн дарга, мэргэжилтэн болон судалгааны багийн гишүүдэд программ хангамжийн сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулав.</p> <p>Мэдээлэл технологийн ажилтнуудад pmt2022 систем</p>	
--	--	--	--	--	---	--

							<p>болон түүний хэрэглэгчийн болоод судалгааны модулийн ашиглалтын сургалтыг 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар 5 удаа зохион байгуулсан. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд 26,900 өрхийн жагсаалтыг бэлтгэсэн. Өрхийн жагсаалтад орсон өрхүүдийг тоологчид хуваарилах болон газрын зурагт тэмдэглэх ажлуудыг хийлгэсэн.</p> <p>Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтан болон багийн ахлагч/сургагч багшийн сургалтын бэлтгэлийг хангаж, сургалтыг 5 дугаар сарын 11-13-ны өдөр 70 хүнийг хамруулан, Улаанбаатар хотод танхимаар, тоологчийн сургалтыг аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь аймаг, дүүргийн хэмжээнд 5 дугаар сарын 21-23-ны өдөр 700 орчим тоологч, ахлагчийг хамруулж танхимаар (хувь зөвлөх цахимаар зөвлөж, чиглүүлж, зарим бүсэд дахин сургалт хийсэн) зохион байгуулсан.</p> <p>Судалгааны урьдчилсан дүнгээр нийт хамрагдах өрхийн 99.1% хамрагдсан бөгөөд 2023 онд багтаан эрүүл мэндийн даатгал, татвар зэрэг төрийн бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх ажил хийж дуусгах юм. Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлээр халамжийг хэрэгцээ, шаардлагатай хэсэгт чиглүүлэх, амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдалтай уялдуулах тул энэ аргачлалын дагуу бүрдсэн мэдээллийн сангийн ашиглалт нэмэгдэх бөгөөд цаашид төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох замаар Монгол Улсын бүх өрхийн амьжиргааг үнэлэх, өрхийн нэгдсэн</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

							мэдээллийн санг үүсгэх шаардлагатай байгаа юм.		
		Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, халамжийн сангаас дэмжлэг хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журмын төслийг боловсруулах	2020	ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоол	2023	Журмын төслийг боловсруулж, ЗГ-ын хуралдаан хэлэлцүүлэхээр хүргүүлсэн байна.	<p>Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалт, Нийгмийн халамжийн тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд нийцүүлэн Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэмжлэг хөнгөлөлт олгох журмуудыг өөрчлөх, шинэчлэн боловсруулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 11 дүгээр сарын 06-ны А/201 дүгээр тушаалаар журмын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулан ажилласан.</p> <p>Журам шинэчлэн батлах тухай” /Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх журам”, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийтийн тэврээр үнэ төлбөргүй зорчих журам”/ Засгийн газрын тогтоолын төсөлд 2023.06.06-ны өдрийн 01/1514 тоот албан бичгээр яамдаас санал авахаар хүргүүлж ирсэн саналуудыг тусгасан. Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ыг шинэчлэн батлуулах Засгийн газрын тогтоолын төсөлд 2023.06.06-ны өдрийн 01/1515 тоот албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн боловсруулсан. Гэвч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хийсэн Процессын дахин инженерчлэлийн хүрээнд иргэд төрийн үйлчилгээг авахад бүрдүүлэх цаасан баримтуудыг цөөлөх, олон шат дамжлагын тоог</p>		

									багасгах, харьяалал харгалзахгүй үйлчилгээг иргэдэд илүү шуурхай, ил тод хүргэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв, Имонголиатай хамтран “Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, цахимжуулах төлөвлөгөө”-г 2023 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулан батлуулах юм. Үүнтэй уялдуулан журмуудыг дээрх өөрчлөлт, зарчимд нийцүүлэх шаардлага үүссэн тул журмын төслийг дахин боловсруулахаар хүлээж байна.		
15	3.1.5.нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	0	0	Төсөв батлагдааг үй тул хэрэгжүүлэх боломжгүй.			2023	-	Засгийн газрын 2023 оны 239 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 550.0 мянган төгрөгт, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр баталсан. Дээрх арга хэмжээний хүрээнд нийт 486.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, 555.0 мянган төгрөг байсан дундаж тэтгэвэр 685.6 мянган төгрөгт хүрч 2016 оны дундаж тэтгэврийн хэмжээтэй харьцуулахад 2.2 дахин нэмэгдсэн. Мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхээр Монгол Улсын	100	

2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталсан.

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор “Тогтоолд өөрчлөлд оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн баталгааг хангах боломж бүрдсэн. Нэмж шаардагдах 109.5 тэрбум хөрөнгийг 2023 оны халамжийн сангийн төсөвт тусгасан.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн батлуулсан. Мөн Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоов. Үүнд:

•Нийгмийн халамжийн тэтгэвэр 288 мянгаас 325 мянган төгрөг,

•Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 288 мянгаас 325 мянган төгрөг,

•Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч

									байгаа иргэний тэтгэмж 84.5 мянгаас 275 мянган төгрөг, •Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэний тэтгэмж 123.1 мянгаас 275 мянган төгрөг Нэмэгдэлийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 12.3%, 2020 оноос хойш нэмэгдээгүй байсан асаргааны тэтгэмжийн хэмжээ 2.2-3.2 дахин нэмэгдэв. 2023 онд Хүн амын амьжиргааны түвшин бүсүүдийн дундаж 282,880 төгрөг байгаа ба тэтгэврийн хэмжээ 7 сараас нэмэгдсэнээр АДТ-ээс 12.9 хувиар илүү болсон. Мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталсан.		
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ:

16	3.3.1.залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	6.0 тэрбум төгрөг	2.0 тэрбум төгрөг	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл /ЗГ-ын тогтоол/	-	Шинээр хийгдэж буй ажил	-	Залуучуудад эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт зохион байгуулж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай, орлоготой болгох зорилготой “Оролцоо” төслийг 2023 онд хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар байгуулж, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжийг дээрх тушаалаар батлуулан, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг	100	
----	--	-------------------	-------------------	---	---	-------------------------	---	---	-----	--

									бүрэн хангаж ажилласан. Батлан хамгаалах яамтай хамтран “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдаж буй 1500 оюутан, залуучуудыг хамруулж, “Оролцоо” төслийн сургалтын үндсэн агуулга болох хувь хүний хөгжил, манлайлал, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар /soft skills/, хөдөлмөрт бэлтгэх чиглэлийн хичээлүүд болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын агуулгыг зааж 2.0 тэр бум төгрөгийг зарцуулав.		
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ

Зорилго 4.Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ:

Зорилт 4.1.Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ:

17	4.1.4. эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг тасралтгүй нэмэгдүүлнэ.	24.4 тэрбум төгрөг ХЭДС	14.8 тэрбум төгрөг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр – 5; Тушаал; удирдамж.	2020	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор үндсэн 6 хөтөлбөрийг баталсан. ХЭҮЗ-ийн 2020 оны 02 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан үндсэн 5 хөтөлбөр болгон баталсан.	2023	Хөтөлбөрүүдийн төслийг хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр оруулан батлуулсан байна. Холбогдох удирдамж, бичиг баримтыг сайдын тушаалаар батлуулсан байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-т хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй	100	
----	---	-------------------------	--------------------	--	------	---	------	---	---	-----	--

								иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг дэмжих, Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 үйл ажиллагааны 34 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/16 дугаар тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна.			
Зорилт 4.3. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ:											
18	4.3.2.даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.			Хуулийн төсөл боловсруулсан эсэх	2020	Шинээр боловсруулах	2023	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 1 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улмаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан 10 аймаг, нийслэлд ахмадууд, залуучууд, сайн дураар даатгуулагчид, үйлдвэрчний эвлэлийн шат шатны байгууллага, ажил олгочдын төлөөлөл, худалдаа аж үйлдвэрийн танхим, хуульчдын холбоо зэрэг газруудаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг зохион байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улсын	100	

									Их хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин баталсан. Энэ дагуу Ажлын дэд хэсгийн гишүүд хуулийн төслийн санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. Улсын Их Хурлын D parliament цахим хуудсанд хандан 21 дэмжсэн санал, зарим холбогдох хуулийн заалтуудад өөрчлөн найруулах 22 саналыг тус тус ирүүлсэн бөгөөд 17,560 дэмжсэн санал өгсөн байна. УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийгмийн бодлогын байнгын хорооны дэд ажлын хэсэг 12 удаа хуралдсан. Мөн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг хэлэлцсэн.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Зорилго 7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ:

19	7.3.6.Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	270.000.000	270.000.000	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээн ий чанар, хүртээмж дээшилж, үйлчилгээн ий бүртгэлийг цахимжуулсан байна.	2020	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх мэдээллийн систем бий болсон.	2023	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системд 2020-2021 оны үйлчлүүлэгчийн бүртгэлийг бүрэн цахимжуулсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний етуslamj.mn цахим системийг “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн програм”, “Иргэд, олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөө өгөх, хэрэглэгчийн програм” гэсэн 2 үндсэн хэсэгтэйгээр хөгжүүлсэн. Бүртгэлийн нэгдсэн програмыг дараах байдлаар хөгжүүллээ. Үүнд: • Back office програмд хүүхдийн бүртгэлийн цэс шинээр үүсгэсэн, • Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн	100
----	---	-------------	-------------	---	------	---	------	---	-----

									<p>хүчирхийллийн хохирогчийн мэдээллийг бүрэн цахимжуулсан,</p> <ul style="list-style-type: none"> • видео контентуудыг YouTube суваг, вебсайтад байршуулж, инфографик, зурган мэдээлэл зэрэг цахим контентуудыг төрөлжүүлсэн, • хэрэглэгчдэд туслалцаа үзүүлэх шугам, хууль эрх зүйн болон сэтгэлзүйн зөвлөгөөг өгөх шугамыг шинээр оруулсан, • хуульч, сэтгэлзүйчтэй шууд холбогдох Фэйсбүүк чатботыг хөгжүүлсэн, • etuslamj.mn facebook пэйж хуудсыг үүсгэсэн, • “Танд туслая” буланг нээж, үйлчлүүлэгчидтэй шууд харилцдаг боломжийг бүрдүүлсэн зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 		
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

Зорилго 9.1. Зорилго 9.1. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.

20	9.1.1.нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг	635.6 сая	635.6 сая	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	2018	19 Нэг цэгийн үйлчилгээний төв 20 Түр хамгаалах байр	2023	Түр хамгаалах байрны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хамгаалах байрны үйл ажиллагаа тогтворжсон байна.	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд¹ заасан 7 төрлийн тусламж, үйлчилгээг 36 Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр үзүүлж байгаа бөгөөд 2023 онд нийт 4037 иргэн үйлчилгээ авснаас 81,9 хувь нь хүүхэд, 18,1 хувь насанд хүрэгч байна.</p> <p>Тус яамнаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, зохицуулагч нарт “Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион</p>	100	
----	---	-----------	-----------	---	------	--	------	---	---	-----	--

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол улсын хууль (2016), 33.1; 35.3; 36.1

нэмэгдүүлсэн байна.							<p>байгуулж, 70 албан хаагчийг чадавхжуулав.</p> <p>Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны сэтгэл зүйч нарт зориулсан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон даван туулагч эмэгтэйчүүдэд тулгамддаг сэтгэл зүйн зөвлөгөөний цогц сургалт”-ыг 2023 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 21 аймаг 9 дүүргийн ТХБ, НЦҮТ-ийн 40 сэтгэл зүйч, ГБХЗХГазар, хэлтсийн мэргэжилтнийг хамруулж, сэтгэл зүйч нарт сэтгэл зүйн зөвлөгөөний цогц багцыг хүлээлгэн өгсөн.</p> <p>Асрамж, халамжийн төвүүд, НЦҮТ, ТХБ-ын нийгмийн ажлын үйлчилгээний төвийн ажилтнуудад Нийгмийн ажлын стандарт, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журмын хэрэгжилтийн арга зүйн сургалт хийж 21 аймаг 9 дүүргийн 65 хүн оролцов. Хүүхдийн эрхийн стандартын эмхэтгэл гарын авлагыг нийт оролцогчдод түгээсэн.</p> <p>Асрамж халамжийн төвүүдийн дунд судалгаа хийж, үйлчилгээний зардлын нормативыг шинэчэн боловсруулах хэлэлцүүлэг хийж саналыг тусган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалаар Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын нормативыг шинэчлэн баталсан.</p> <p>Хүүхэд хамгааллын үйлчилгээний магадлан итгэмжлэх журмын дагуу Асрамж халамжийг төвийг магадлан итгэмжилж 2023 онд нийт</p>		
---------------------	--	--	--	--	--	--	---	--	--

17хүүхдийн асрамжийн төв магадлан итгэмжлэлд орж зөвшөөрөл авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор тус яам зохион байгуулсан “Эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний чуулганы зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд:

1.“Эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн цогц үйлчилгээг тодорхойлох үйлчилгээний аргазүй, аргачлал”-ыг боловсруулсан.

2.21 аймаг, 9 дүүргийн төр, төрийн бус байгууллагын 70 гаруй мэргэжилтэнд “Эрэгтэйчүүдтэй ажиллах арга зүйн сургалт”-ыг 2023 оны 05 дугаар сарын 11-12-ны өдөр зохион байгуулж, төр, төрийн бус байгууллагууд хамтран орон нутагтаа эрэгтэйчүүдийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах нэгдсэн арга зүйг эзэмшсэн.

3.НҮБХАС, ШХА-тай хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд нийслэлийн Чингэлтэй дүүрэгт “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө, мэдээлэл, өгөх жишиг төв”-ийг анхлан байгуулж, 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр буюу “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан үйл ажиллагааг нээсэн. Төвийн үйл ажиллагаа эхэлснээс хойших 15 хоногийн хугацаанд 10 эрэгтэй зөвлөгөө, мэдээлэл авсан байна.